

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-13

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 14-30

1.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 14-29

2.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 29-30

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 20 цаг 56 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, Н.Номтойбаяр, Л.Гантөмөр, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан.

Нэг.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Засгийн газрын референт О.Дөлгөөнтуул, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх П.Зохихсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төсөл

Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Дам.Цогтбаатар нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “4/Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам” гэснийг “4/Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Дам.Цогтбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “9/Гэр бүл, хүний хөгжлийн яам” гэснийг “9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “10/Зам, тээврийн хөгжлийн яам” гэснийг “10/Зам, тээврийн яам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Дам.Цогтбаатар нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайд,” гэснийг “11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хүний хөгжлийн сайд,” гэснийг “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайд,” гэснийг “17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “бүсчилсэн хөгжлийн бодлого” гэснийг “бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлого” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын дарааллыг доор дурдсанаар өөрчлөх:

“бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлого, чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлт, стандартчилал, хэмжил зүйн асуудал, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал, лабораторийн үйл ажиллагаа бодлого, төлөвлөлт, гамшгаас хамгаалах асуудал, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой асуудал, агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэмжээ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “онцгой байдлын асуудал эрхэлсэн” гэснийг “бүсчилсэн хөгжлийн асуудал эрхэлсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд “лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлт;” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 7

Бүгд: 20

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт 21 цаг 20 минутаас 21 цаг 25 минутад хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: 5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлт” гэснийг “чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: 6.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Гэр бүл, хүний хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээний “хөдөлмөрийн нөхцөл” гэсний дараа “хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, С.Амарсайхан нар үг хэлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Боловсролын сайдын эрхлэх ажлын хүрээнд “зэргийн болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах;” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Э.Болормаа, О.Номинчимэг нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээний “иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;” гэснийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 8 |
| Татгалзсан: | 12 |
| Бүгд: | 20 |

40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй

9.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээний “иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;” гэснийг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 10 |
| Татгалзсан: | 10 |
| Бүгд: | 20 |

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 9 |
| Татгалзсан: | 11 |
| Бүгд: | 20 |

45.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар санал хураалтын төхөөрөмж сааталтай байгаа тул санал хураалтыг илээр, гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 11 |
| Татгалзсан: | 9 |
| Бүгд: | 20 |

65.0 хувийн саналаар горимын санал санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20

55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: 9.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээний “иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;” гэснийг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний “биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого” гэсний өмнөх “нийтийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Доржхандын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “гадаадын хөрөнгө оруулалтын” гэснийг “гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайд болон Засгийн газрын гишүүн бүрийн эрхлэх ажлын хүрээнд “төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал” гэснийг тохиолдол бүрд “орчны бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 20
Бүгд: 20
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний “залуучуудын хөгжлийг дэмжих бодлого” гэснийг “залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх ажлын хүрээний “хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал” гэснийг мөн хэсгийн 10 дахь заалтад шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 14
Бүгд: 20
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “иргэний боловсролын албан болон албан бус хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлэх;” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 12
Бүгд: 20
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Л.Энх-Амгалан нарын гаргасан, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Тэргүүн шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого” гэсний дараа “төлөвлөлт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “бүсчилсэн хөгжлийн” гэж, мөн зүйлийн 7.6 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийн “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “Бүсчилсэн хөгжлийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.8 дахь заалтын “бүс нутгийн хөгжлийн” гэснийг “эдийн засаг, хөгжлийн” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арав.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван нэг.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван хоёр.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван гурав.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван дөрөв.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван тав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван зургаа.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван долоо.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван найм.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван ес.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорь. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсгийн “Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэснийг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, О.Номинчимэг нар Байнгын хорооны хуралдаанд санал хураалгаж, олонхын санал аваагүй зарчмын зөрүүтэй саналуудаа татаж авав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 22 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 2024.07.09-ний өдрийн 22 цаг 18 минутаас 2024.07.10-ны өдрийн 03 цаг 04 минут хүртэл завсарлав.

Хоёр.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Засгийн газрын референт О.Дөлгөөнтуул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний “залуучуудын хөгжлийг дэмжих бодлого” гэснийг “залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 03 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 25 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 2024.07.10-ны өдрийн 3 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
20 цаг 56 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны гишүүддээ оройн мэнд хүргэе. ТББХ-ны гишүүдийн ирц хуралдааны шаардлагыг хангаж байгаа учраас 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн ТББХ-ны оройны хуралдааныг эхэлснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. 1 асуудал хэлэлцэнэ. Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн хууль, тогтоолын төслүүд, Засгийн газар 2024 оны 7 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Байхгүй тул хэлэлцэх асуудлыг, асуудалдаа оръё.

Нэг.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

ЗГ-ын бүтцийн тухай хууль, ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Дэгийн тухай хуулийн 39.10-аар Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх, бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь

өөрчлөх бол тухайн бүлгийн зүйл бүрээр хэлэлцэнэ. 39.11 гишүүн хуулийн төслийн тухай тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

Хууль, тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Байхгүй байна. Мөн асуулт байхгүй учраас хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцье. Энэ хэн хариулах юм бэ? Ажлын хэсэг чинь, ажлын хэсгээ оруул даа. Ажлын хэсгийг танилцуулъя. Бямбажавын Ганбат ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга, Пүрэвийн Зохихсүрэн Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Чулуунбаатарын Дондогмаа ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Очиржавын Дөлгөөнтуул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ЗГ-ын референт. Хэлэлцэх асуудалдаа оръё.

ЗГ-ын бүтцийн тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Гишүүдээс Номинчимэг гишүүнээс 1 дүгээр зүйл дээр зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирүүлсэн байна. ЗГ-ын бүтцийн тухай хуулийн төслийн талаарх санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “4/Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам” гэснийг “4/Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж өөрчлөх. Номинчимэг гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая. Номинчимэг гишүүний микрофоныг.

О.Номинчимэг: Эрхэм гишүүддээ энэ оройн мэндийг хүргэе. Энэ нэршил бас нэлээн сая нэгдсэн чуулган дээр ч ярилаа, ТББХ-ны өглөөний уулзалт дээр ч гэсэн бид бас ярилцсан. Justice гэдэг үгэн дээр бас их ярилцаад байх шиг байна. Тэгээд байр сууриа дахин илэрхийлж байна. Justice гэдэг бол зөвхөн шударга ёс гэдгээс гадна хууль зүйн систем өөрөө улс орны энэ системийг бас хэлдэг. Бид нар энэ дээр шударга ёс гэж нэмнэ үү байна уу, үгүйгээр манай ХЗДХЯ-ны Англи хэлний нэршил Ministry of justice and home affairs гээд явж байгаа. Тэгээд энийг чиг үүрэг өөр ямар нэгэн бүтэц

байхгүйгээр бид нар ингэж авч явах гэж байгаа бол энэ дээр давхардсан ийм нэр томъёолол байх нь хэр зохимжтой вэ? Хууль зүй гэдэг үг дотор бид нар энэ бас шударга ёсыг тогтоохын төлөө энэ чиглэл нь явж байгаа.

Ер нь шударга ёс гэдэг үгийг бол бид бас зөвхөн нэг яамны нэрэн дээр гэхээсээ илүү ер нь бид нарын үнэт зүйл, цаашаа бүгд хэрэгжүүлэх ийм л үнэт зүйл байх ёстой учраас хэрвээ зөвхөн энэ justice гэдэг үгэн дээр бид нар бас ярилцаж байгаа бол энэ өөрөө хууль зүй гэсэн утгатай юм. Энэ маань өөрөө тусчихсан байгаа юм гэдэг саналтай байгаа юм. Тэгээд хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Мөн 1 дүгээр зүйл дээр Цогтбаатар гишүүн зарчмын зөрүүтэй санал. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Дам.Цогтбаатар: Би алин дээр нь сууж байна вэ, энэ чинь нөгөө бүртгэхгүй байгаа болохоор. Би Номинчимэг гишүүний ярьж байгааг 100 хувь дэмжиж байгаа юм. Энэ Justice гэдэг үг бол шударга ёс гэдэг агуулга байдаг боловч хуулийн контекстэд хэрэглэгдэж байгаа тохиолдолд ганцхан утгаар ойлгогдоно. Энэ бол шүүх засаг юу, шүүх тогтолцоо, хууль зүйн тогтолцоог, хуулийн тогтолцоог бүхэлд нь хэлж байгаа юм. Шударга ёс гэсэн үг бол энэ контекстээ биш.

Жишээлбэл Justice гэж Америкийн хуульд бол юу хуулийн практикт бол Justice гэдэг чинь шүүгчийг хэлж байгаа. Жишээлбэл давах шатны шүүгчийг Justice гэнэ. Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг бол Chief Justice гэнэ. Тэгэхээр энийг чинь ерөнхий шударга ёс гэж нэрлэх үү? Justice гэдэг үг шударга ёс гэж байгаа учраас гээд. Тэгэхээр энэ бол тэгж хэрэглэгддэггүй. Энэ бол яг шүүх тогтолцооныхоо энэ тогтчихсон нэр, хууль зүйн тогтолцооныхоо тогтчихсон нэр учраас яг энүүгээр нь хэрэглэх ёстой.

Тийм учраас Шударга ёс гэдэг үгийг энэ юунд бол оруулж болохгүй.

Энэ дээр жишээлбэл энэ үгний цаад агуулга нь өөрөө латин юу Римийн эзэнт гүрний хуулиас гаралтай л даа. Jus гэж бол өөрөө бас шударга ёс гэсэн үг. Гэхдээ жишээлбэл хуулийн хүрээнд яг тэр үед ч гэсэн зөвхөн хуулийг л хэлдэг байсан. Одоо Jus sanguinis, Jus Soli, Jus gentium, Jus naturale, Jus sevilla гээд энэ дандаа хуулийн тухай ярьж байгаа. Шударга ёсны тухай ерөөсөө биш. Нөгөө талаасаа энд надаа Black's law dictionary гээд байж байна, Justice гээд. Administration of law гэж байгаа юм. Department of justice гэдэг дээр түрүүн тийм юм яриад байна лээ. Department of justice гэдэг дээр хуулийг хэрэгжүүлэх хамгийн гол институт нь шүүх дээ АНУ-ын.

Тэгэхээр энэ дээр ахиад тэр шударга ёсны тухай асуудал үгийн этимологи цаад утгаараа байгаа болохоос биш энэ хууль хэрэглээ дээр бол яг ганц утгаараа байдаг шүү. Илүү үүнийг европ өөр хэлнүүд дээр үзье л дээ. Германд жишээлбэл Германаар gerechtigkeit гэж шударга ёс гэсэн үг. Гэтэл Хууль зүйн яамыг бол Bundesministerium der Justiz гэдэг, Австри дээр бол Bundesamt für Justiz гээд, justiz буюу хууль зүй гэсэн үг. Орос дээр бас юстиция гэдэг, Министерство юстиции гээд. Түүнээс Министерство справедливости ч юм уу, Германаар тэр Bundesministerium gerechtigkeit гэж хэлдэггүй. Тийм учраас энэ бол үнэхээр яг таашаа ойлголт явж байгаа учраас энийг бол сольж өгөөч гэмээр энийг хасаж өгөөч гэж хүсэж байна.

Англи хэл дээр доктор гэдэг чинь эмч бас эрдмийн зэргийг хэлж байгаа. Тэгээд физикийн ухааны доктор гэхээр физикийн ухааны эмч гэж орчуулах гээд байгаа болж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бол үнэхээр ингэж хэрэглэж болохгүй шүү л гэдэг саналыг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Өөр, ЗГ-ын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Ариунзаяа гишүүн. Зөвхөн 1. ЗГ-ын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр. Номинчимэг, Цогтбаатар гишүүдийн гаргасан ЗГ-ын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “4/Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам” гэснийг “4/Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй саналаар санал хураая. Энэ чинь үүгээрээ явж байна уу? Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. 20 гишүүнээс 13 гишүүн буюу 65 хувиар санал дэмжигдлээ. Доржханд гишүүнийг дэмжсэнд протоколд хөтлөөд тэмдэглээрэй.

Мөн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Зулпхар, Лувсанжамц, Эрдэнэбат, Энхцэцэг, Энхтүвшин, Хэрлэн, Саранчулуун нарын гишүүдээс гаргасан Төслийн 1 дүгээр зүйлийн “9/Гэр бүл, хүний хөгжлийн яам” гэснийг “9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж өөрчлөх. Зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах уу? Ариунзаяа сайд, гишүүн.

А.Ариунзаяа: Гишүүдэд оройн мэнд хүргэе. Өглөө хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дээр бас саналаа хэлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны чиглэл чиг үүрэгт ямарваа нэгэн өөрчлөлт ороогүй. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал чухал. Хүн амын хөгжил их чухал асуудал учраас нэрийг нь хэвээр үлдээх, мөн дээрээс нь хууль санаачлагчийн Ерөнхий сайдын гэр бүлийн асуудлыг чухалчилж байгаатай холбоотойгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэсэн нэршилээр нь явах горимын санал гаргаж байна. Энэ саналыг Ерөнхий сайд сая чуулган дээр мөн хүлээж авч байгаагаа илэрхийллээ.

Энэхүү санал маань үйлдвэрчин, тэнхим, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл мөн нийгмийн салбарын төлөөлөл, манай салбарын

төлөөллийн бас санал юм гэдгийг онцлон хэлье. Дэмжиж өгнө үү, баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Нэр бүхий 8 гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураана. Гэр бүл, хүний хөгжлийн яам гэснийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж өөрчлөх томъёоллоор санал хураая. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал. 1 дүгээр зүйл дээр Пүрэвдорж гишүүнээс Зам, тээврийн хөгжлийн яам гэснийг Зам тээврийн яам гэж өөрчлөх. Зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах уу? Пүрэвдорж гишүүний микрофон.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам гээд Эдийн засаг, хөгжлийн яам гээд бас тусдаа яамтай. Тэгэхээр ер нь бол бид нар хөгжлийн асуудлыг ярих тохиолдолд бас тодорхой хэмжээгээр яг энэ нэгдсэн бодлоготойгоор, нэгдсэн бусад бүх яамдын үйл ажиллагаатай холбож энэ асуудлыг шийдвэрлэх ёстой. Тэгэхээр ер нь бол зам ер нь бол хөгжлийн асуудал Эдийн засаг хөгжлийн яаман дээр бас тодорхой хэмжээгээр шийдвэрлэх учраас энэ хөгжлийн гэдэг үгийг хасах саналтай байгаа юм. Дэмжиж өгөөрэй.

Ц.Сандаг-Очир: Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 20 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ. Амарсайхан гишүүн дэмжсэнд протоколд тэмдэглээрэй.

Төслийн 2 дугаар зүйл, ЗГ-ын бүтцийн тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. ЗГ-ын бүтцийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Түрүүн 1 дүгээр зүйл дээр Номинчимэг гишүүн, Цогтбаатар гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 2 дугаар зүйл дээр Төслийн 1 дүгээр зүйлийн “11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайд гэснийг “11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал. 12 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар дэмжигдлээ санал.

Энэ мөн адилхан уу? Мөн адилхан нэр бүхий 8 гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулаад Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийн талаарх санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хүний хөгжлийн сайд;” гэснийг “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;” гэж өөрчлөх. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Мөн Пүрэвдорж гишүүний зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулаад ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуулийн 117-гийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд гэж санал хураалт өөрчлөх. Санал хураалт. 14 гишүүн 70 хувийн саналаар дэмжигдлээ. Монгол Улсын ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу, байгаа шүү дээ? Нөгөө саналууд чинь, чи түрүүн авсан даа наана чинь. Энэ байна.

Миний зүгээс бас зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа. Төслийн 3.20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Монгол Улсын Шадар сайд гэсэн хэсэг дээр Бүсчилсэн хөгжлийн бодлого гэснийг бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлого гэж өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй санал оруулж байна. Учир нь Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хороо Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллахаар заасан байгаа. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д зааснаар Үндэсний хорооны дарга нь Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн байна гэж заасантай нийцүүлэх шаардлагатай байгаа учраас энэ зарчмын зөрүүтэй саналыг оруулж байна. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Төслийн 3.20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг 2.Монгол Улсын Шадар сайд гэсэн хэсэг дээр Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлыг энэ дарааллаар өөрчлөх найруулгын санал байна. Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлого, чөлөөт бус, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлт, стандартчилал хэмжил зүйн асуудал, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал, лабораторийн үйл ажиллагаа бодлого, төлөвлөлт, гамиггаас хамгаалах асуудал, хойшлуулишгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой асуудал, агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэмжээ гэж дарааллыг өөрчлөх.

Учир нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын чиг үүргийн эхэнд Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлого гэж

оруулахаар сая санал дэмжигдсэн. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хүрээнд чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлт гэж дарааллын 2-т бичихээр байгаа юм. Тийм учраас энэ зарчмын зөрүүтэй саналыг бас гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Энэ бол найруулгын санал учраас санал хураах уу? Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал. Төслийн 3.20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Монгол Улсын Шадар сайд гэсэн хэсэгт Засгийн газрын бүрэлдэхүүн хэсэгт Монгол Улсын Шадар сайд онцгой байдлын асуудал эрхэлсэн гэснийг Монгол Улсын Шадар сайд Бүсчилсэн хөгжлийн асуудал эрхэлсэн гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал. Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал. Төслийн 3.20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Монгол Улсын Шадар сайд гэсэн хэсэг дээр лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого төлөвлөлт гэж шинээр нэмэх. Учир нь төрийн байгууллагуудын дэргэдэх үндэсний лавлагаа лаборатори, хорио цээрийн лаборатори, мал эмнэлгийн лаборатори, эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний лавлагаа лаборатори зэрэг хоорондоо уялдаа холбоогүй, нэгдсэн мэдээллийн сангуй, тархай бутархай байгаа лабораториудыг нэгтгэн зохион байгуулж олон улсын жишигт нийцүүлж, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх хүрээнд асуудалд оруулж, нэгдсэн бодлого төлөвлөлт, зохион байгуулалтад оруулах нь зүйтэй гэж үзэж энэ зарчмын зөрүүтэй саналыг оруулж ирж байна. Санал хураалт дэмжье гэсэн. 13 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал. Төслийн 3.20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Монгол Улсын Шадар сайд гэсэн

хэсэг дээр бүсчилсэн хөгжил хариуцсан Шадар сайдын чиг үүрэгт өөрчлөх талаар зарчмын зөрүүтэй санал. Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлт гэснийг чөлөөт бүсийн эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт болгож өөрчлөх. Учир нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын, байж байгаарай энэ хамраас цус гараад байна. Тийм.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт хуралдааныг 21 цаг 20 минутаас 21 цаг 25 минутад хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: Аль дээр явж байгаа юм бэ? Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлт гэснийг чөлөөт бүсийн, чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт болгож өөрчлөх. Санал гаргасан Сандаг-Очир гишүүн гаргасан байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Дараагийн санал хураалт. Монгол Улсын ЗГ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Гэр бүл, хүний хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээний хөдөлмөрийн нөхцөл гэсний дараа хөдөлмөрийн аюулгүй байдал гэж нэмэх. 2 төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Боловсролын сайдын эрхлэх ажлын хүрээнд зэргийн болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах гэж нэмэх. Тус тусад нь хураалгах юм байна даа. Эхлээд 1 дүгээр саналаар нь. Зулхар гишүүн саналаа тайлбарлах уу? Зулхар гишүүнд микрофон өгье.

С.Зулхар: Байнгын хорооны гишүүдийн оройн амгаланг айлтгая. Түүрүүн би бас өглөөний хуралдаан дээр тайлбарласан юм байгаа юм. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал бол хөдөлмөрийн

харилцааны, хөдөлмөрийн нөхцөлийн суурь бодлогуудын зохицуулалтуудын нэг. 2,1 сая хөдөлмөрийн насны болон 1,2 сая ажиллах хүчний гол асуудал юм байгаа юм. Тэгээд энийг бол бид нар нэгдэж орсон 3 конвенц байгаа. Энийг орхигдуулсан байсныг нэмж байгаа юм.

2 дахь юм бол Боловсролын яамны чиг үүрэг дээр болбол угаасаа энэ 2 яамны хоорондын үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр энэ чиг үүргийг бас бол нэмж оруулья гэсэн байдлаар сайдынх нь эрхлэх асуудал ингээд нэмж тодотгож байгаа юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг саналтай юу, болох уу? Бас төсөл оруулсан хүмүүсийн саналыг, байр суурийг. Ганбат дарга. Төслөө оруулж байгаа нөхдүүдийн юмыг бид нар дураараа хамаагүй өөрчлөөд байж болохгүй шүү. 6 дугаар микрофон. Хууль санаачлагч.

Б.Ганбат: Хууль санаачлагчийг төлөөлж байгаа юм. Тэгээд Үндсэн хуулийн 39.3-д зааснаар Монгол Улсын Ерөнхий сайд ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүний түүнд өөрчлөлт оруулах хуулийг бол Ерөнхийлөгчтэй зөвшилцөөд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэсэн энэ заалтынхаа хүрээнд хуулийн төсөл өргөн баригдсан байгаа. Саяын одоо санал хураалгасан асуудлууд дээр яг өргөн барьсан хуулийн төсөл дээр болбол ЗГ-ын бүтэц, бүтцээ дагаад бүрэлдэхүүн нь орж ирж байгаа. Бүтэц дээр болбол ер нь болбол Ерөнхий сайдын ерөнхий өөрийнх нь барьж байгаа концепцын асуудлууд орж ирсэн.

Эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан буюу бүрэлдэхүүнээр нь тооцох юм болбол ЗГ-ын Тэргүүн шадар сайд гэдэг дээр бол эдийн засгийн нэгдсэн бодлого нь яваад, бүсчилсэн хөгжлийн асуудал болбол Монгол Улсын Шадар сайд дээр 2 хуваагаад ингээд явж байсан. Сая санал хураагаад нөгөө юу руугаа ороод явчихлаа. Тэгээд бүсчилсэн хөгжлийн бус нөгөө өөрийнх нь хууль дээр

бас өөрчлөлт оруулаад явж байгаа юман дээр ингээд задлаад явчихлаа. Тэгэхээр ерөнхийдөө концепц нь болбол ингээд нэлээн задрах шинжтэй болоод явж байна. Энэ дээр манай Улсын Их Хурлын эрхэм гишүүд бас анхаарлаа хандуулаач гэж хэлмээр байна.

Саяын хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудал болбол заавал энэ хуулиар тусгайлан ЗГ-ын хуулиар тусгайлан заах шаардлага бол байхгүй. Яагаад гэх юм болбол ЗГ-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-д ЗГ-ын гишүүдийн үндсэн чиг үүргийг ЗГ-ын тухай хуулиар, бусад тодорхой ажил, чиг үүргийг болбол бусад хуулиар зохицуулна гэдэг энэ хуулийнхаа ерөнхий концепцын хүрээнд энэ хуулийн төсөл маань боловсруулагдаж, бичилт нь хийгдэж орж ирсэн. Тэгэхээр тэрнийхээ хүрээнд болбол бусад хууль тогтоомжоор зохицуулаад явах бүрэн бололцоо нь бол байж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр болбол заавал энэ эрхлэх асуудлын хүрээнд дээр асуудал нэмээд байх, тэгээд детальчилсан, нарийвчилсан илүү асуудлыг нэмээд байх шаардлага бол байхгүй байна. Энэ дээр Их Хурлын гишүүд маань бас анхаарлаа хандуулаач гэж хэлмээр байна.

Ц.Сандаг-Очир: Шадар сайд, Шадар сайдын микрофоныг өгье. Тайлбар хэлэх үү?

С.Амарсайхан: Тийм, Ганбат дарга сая яах вэ бид түрүүн бас жоохон буруу ойлголт явах шиг болсон. Энэ эрхлэх асуудлын хүрээнд ерөөсөө өөр орж байгаа юм байхгүй. Шадар сайд угаасаа Эдийн засгийн асуудал хариуцсан Шадар сайд, Монгол Улсын Шадар сайд гээд 2 явж байгаа шүү дээ. Тэр хүрээнд нөгөө бүсчилсэн хөгжлийн асуудал гэдгээ бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт гэдэг тодотголыг нь хийгээд, чөлөөт бүс, нөгөө тусгай бүс гэдгээ тодотгож өгч байгаа асуудал. Дээрээс нь стандартчилал, хэмжил зүйн асуудал өөрөө Шадар сайдын харьяанд байгаа учраас тэр лабораторийн асуудал,

лаборатори ч гэсэн байгаа юм. Тэгэхээр лабораторийн нэгдсэн бодлогын асуудал гэдэг ийм тодотголууд явж байгаа байхгүй юу. Зүгээр техникийн шинж чанартай эрэмбэ дараанууд.

Нөгөө талаараа болбол тэр нөгөө бүсчилсэн хөгжлөө зүгээр тэр дотор нь эрхлэх асуудлынхаа хүрээнд эрэмбэлэх асуудал дээр л явж байгаа юм. Тэрнээс өөрөөр ямар нэгэн тийм нэр томъёоны өөрчлөлт гэдэг юм уу, дахиж нэмж оруулж ирж байгаа асуудал сая Сандаг-Очир гишүүний гаргасан санал дээр ямар нэгэн асуудал байхгүй. Энэ жоохон ойлголтын зөрөө, түрүүн бас бид нар тодруулсан нөгөө ирж өөр асуудал яваад байна гэдэг тэр тийм асуудал ерөөсөө байхгүй шүү энэ дээр.

Ц.Сандаг-Очир: Зарчмын зөрүүтэй санал Улсын Их Хурлын гишүүн Зулхар гишүүнээс гаргасан ЗГ-ын бүтцийн тухай хуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Гэр бүл, хүний хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээний хөдөлмөрийн нөхцөл гэсний дараа хөдөлмөрийн аюулгүй байдал гэж нэмэх. Тайлбарлах уу саналаа? Зулхар гишүүний микрофон.

С.Зулхар: Би түрүүн тайлбарыг нэг бол дутуу хэлсэн юм шиг байна. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дээр энэ чиг үүргийг хэрэгжүүлж байгаа сайдын хувьд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо нь байдаг. Тэгээд энэ болбол ер нь бас яах вэ бусад хуулиар зохицуулагдсан ч гэсэн нэгэнтээ чиг үүрэг нь тодорхой байгаа болбол тэр чиг үүргийг эрхлэх асуудалд нь зааж өгөх нь болбол зүй ёсны. Энэ захиргааныхаа процесс талаасаа ч тийм байдаг. Энийг бас харгалзаач гэж байгаа юм.

2 дахь зүйлийг болбол ер нь ЗГ-ын бүрэлдэхүүнд орж байгаа бүх жишээ нь улс төрийн намуудын хувьд хөдөлмөр

эрхлэлтийн асуудлыг их чухалчилж байгаа юм. Тэгээд бид боловсрол дээр болбол энийг чухалчилна гэдгээ аль, аль тал нь хэлчихсэн. Боловсролын хөтөлбөрүүдийг зэргийн болон жишээ нь мэргэжлийн байхаас үл шалтгаалаад хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулахгүй болбол энэ бүх зүйл чинь болохоо байлаа гэдгийг болбол ярьсаар байгаад, хэлсээр байгаад энийг тохирчихсон учраас энийг Боловсролын сайд асуудал эрхэлсэн сайдын чиг үүрэгт бол эрхлэх асуудалд оруулж өгөх нь болбол зүйтэй байх гэсэн ийм байдлаар санал гаргасан юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ойлголоо. Зулхар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар Зулхар гишүүний зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Мөн ЗГ-ын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Боловсролын сайдын эрхлэх ажлын хүрээнд зэргийн болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах гэж нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргасан. Зулхар гишүүн саналаа тайлбарлая.

С.Зулхар: Сандаг-Очир дарга би сая тайлбар өгчихсөн юм. Саяын 2 дахь асуудалтай холбогдуулаад тийм.

Ц.Сандаг-Очир: Тэгвэл санал хураалт. 20 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг, Болормаа, Баярбаатар, Сайнзориг нарын гишүүдээс ЗГ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх

ажлын хүрээний иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл гэснийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх ажлын хүрээнд шилжүүлэх гэж өөрчлөх. Тайлбарлах уу? Шаардлагагүй юу? Санал хураалт. Зарчмын зөрүүтэй саналаас асуулт байна уу? Тэмүүжин гишүүн асуулт.

Х.Тэмүүжин: Ер нь бол энэ эд хөрөнгийн бүртгэл болон иргэний бүртгэл энэ тэрийг холиод нэг том агенту байгуулчихсан бид нарын бол алдаа байсан. Тэрийг бол бид нар хүлээн зөвшөөрөх ёстой. Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэл бол татварын алба юм уу эсвэл өөр бусад чиг үүрэг дээр байж болно. Харин иргэний бүртгэлийг ХЗДХЯ-наас салгана гэдэг бол харин байж болохгүй.

Иргэний бүртгэл гэдэг чинь дотоод хэргийн яамны чинь үндсэн чиг үүрэг шүү дээ. Тэр бүртгэл дээр систем нь өөрөө ажиллах ёстой, тэр бүртгэл дээр суурилж дараа дараагийнх нь чиг үүргүүд нь хэрэгжих ёстой. Ингээд байгууллагынх нь чиг үүргээ бүтнээр нь ингээд Шадар сайд руу Хэрэг эрхлэх газрын дарга руу аваад явчихаар дотоод хэргийн яамны чинь гол суурь алга болж байна шүү.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая. Сайнзориг гишүүний микрофон. Сайнзориг гишүүний микрофон, шууд хуруугаа дараад. Одоо унилаа.

П.Сайнзориг: Би Сандаг-Очир даргаа ингэсэн юм. Цогтбаатар, Номинчимэг, өөр хэн гишүүн гэсэн бэ? Би энэ 3 гишүүнээс бол өөр. Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд аваачиж өгье гэж өгч байгаа. Хэрэг эрхлэх газрын дарга гэхээсээ илүүтэй Ерөнхий сайдын бүрэн эрхлэх асуудлын хүрээнд өгөөд, Хэрэг эрхлэх газар л угаасаа Ерөнхий сайдын агентлагуудтай харьцаад явна шүү дээ. Тэгэхээр энэ зарчмаар нь

хураалгаж өгөөч. Унавал тэгээд нөгөө саналаар нь хурааж өгөөч л гэж хүсээж байна.

Ц.Сандаг-Очир: Тэгээд энэ Номинчимэг гишүүн, Болормаа гишүүн, Баярбаатар гишүүдийнх чинь болохоор Хэрэг эрхлэх газрын харьяанд гээд байгаа юм байна. Сайнзориг гишүүнийх болохоор Ерөнхий сайдын харьяанд гэж байгаа юм байна тийм үү? Номинчимэг гишүүн саналаа тайлбарлая. Номинчимэг гишүүний микрофон.

О.Номинчимэг: Энийг бас өмнөх хэлэлцэх эсэх дээр бас дурдсан асуудал. Энэ улсын бүртгэлийн асуудал ерөнхийдөө би бас цаашаа хаашаа харж явах вэ гэхээр Тэмүүжин гишүүнтэй бол санал нэг. Бид энэ улсын бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, иргэний бүртгэлийг цаашид нь салгах ёстой. Харамсалтай нь одоогоор энэ болбол боломжгүй байна.

Гэхдээ бид цаашидаа газрын бүртгэл, кадастрын бүртгэл, эд хөрөнгийн бүртгэлийг ер нь болбол олон улсын жишгээр энд болбол бас нөгөө татвар санхүүгийн асуудал яригддаг учраас энэ асуудлыг эрхэлж байгаа яамны харьяа, улсын хуулийн этгээдийн улсын бүртгэл бол худалдаа аж үйлдвэр юу гэдэг юм тийм ээ энэ чиглэлийн юм руу нь явах ёстой. Бид болбол одоо улсын бүртгэлийг бас ингээд реформын суурь байгаа тийм ээ, кадастр байна, газрын энэ суурь асуудлыг яахад 2, 3 яам ингээд хоорондоо амбицлаад бид нар энэ дээрээ бүртгэлээ байна, бид нар энэ дээрээ кадастр байна гэдэг энийг больж, бүртгэлээ нэгтгэхийн тулд салбар хоорондын энэ зохицуулалтыг буюу ЗГ-ын яг энэ гал тогоог баздаг Хэрэг эрхлэх газар дээр нь өгчихье. Энэ реформоо хийе.

Цаашид энэ дээр бас энэ 3 бүртгэлийг бол салгах ажлыг ч гэсэн энэ хүрээнд бас системийг нь бий болох асуудлыг ЗГ-т бас үүрэг чиглэл болоод Улсын Их Хурлаас өгөөд энэ бүртгэлийн

асуудлыг илүү цааш нь хөгжүүлж явъя гэсэн ийм саналтай байгаа юм. Тийм учраас ЗГ-ын, Ерөнхий сайдын гал тогоог базаж байгаа Хэрэг эрхлэх дээр юутай ч энийгээ шилжүүлээд, энэ асуудлаа цааш нь илүү бид нар хяналтаа тавиад, шаардлагаа тавиад явъя гэсэн ийм саналаар энийг гаргасан байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Номинчимэг, Болормаа, Баярбаатар 3 гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгах гэж байна. Энэ санал дэмжигдвэл иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг Хэрэг эрхлэх газрын даргын мэдэлд, эрхлэх ажлын хүрээнд шилжүүлнэ. Энэ санал дэмжигдэхгүй тохиолдолд Сайнзориг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгана зөв үү? Санал хураалт.

Энэ санал унасан учраас Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгая. Санал хураалт. Мөнхбаатар гишүүн. Үгүй ээ Мөнхбаатар гишүүн санал хураалт эхлэхээс өмнө ажиллахгүй байна гэсэн юм. Мөнхбаатар гишүүн горимын санал гаргая.

Л.Мөнхбаатар: Энэ микрофон чинь ажиллахгүй байна. Энэ юуныхан техникийнхэн хүрээд ирээч энийгээ. Төхөөрөмж ажилласангүй, техникийнхэн ирж шалгаад үзчих.

Ц.Сандаг-Очир: Мөнхбаатар гишүүн санал хураалт эхлэхээс өмнө ажиллахгүй байна гэдгээ хэлсэн юм. Мөнхбаатар гишүүнд микрофон өгье. Алив энэ техникийнхэн. Номинчимэг гишүүн горимын санал гаргая. Номинчимэг гишүүний микрофон.

О.Номинчимэг: Энэ техник технологийн энэ нөгөө хэрэглээтэй холбоотой миний бас санал ингээд нөгөө хугацаа нь дуусаад татгалзсан руу орсон байна. Тэгэхээр энэ санал хураалтыг

хүчингүйд тооцож өгнө үү гэж хүсээж байна.

Ц.Сандаг-Очир: Мөнхбаатар гишүүнийх болж байна уу? Санал хураалт явуулах гээд байна. Номинчимэг гишүүний гаргасан саяын санал хураалтыг хүчингүй болгох томъёоллоор. Пүрэвдорж гишүүнээ хураахаас өмнө санал хураалтын дүн гарахаас өмнө минийх ажиллахгүй байна гэдгээ хэлсэн байхгүй юу. Санал хураалт явуулах боломжтой байна уу? Энэ Мөнхбаатар гишүүний энэ техник тоног төхөөрөмжийг янзлаадхаач. Номинчимэг гишүүний гаргасан горимын саналаар түрүүний санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. Үгүй ээ үгүй, наадах чинь санал хураалтын дүн гарахаас өмнө хэлээд байна шүү дээ Пүрэвдорж гишүүн. Бүгдээрээ харж байна шүү дээ. Хэн хэний санал, машин нь санал хураалтад яахгүй байна, Жавхлан гишүүнийх, бүгд, Амарсайхан гишүүнийх, бүгд улаан болчихлоо гээд санал хураалтаас өмнө хэлээд байна шүү дээ. Дүн гарчихсаны дараа биш.

Яах ёстой юм бэ? Энэ техник тоног төхөөрөмжийн санал хураахад. Яах вэ саналаа илээр явуулах уу? Горимын санал гаргаж, гар өргөж. Одоо ингээд энэнээс болоод ингээд хугацаа бага байна, оройтлоо. Тэгье дэг дээр байгаа учраас санал хураалтыг гар өргөж, илээр явуулъя. Горимын санал хэн гаргах вэ? Баярбаатар гишүүн санал гаргая.

Б.Баярбаатар: Гар, саналыг гар өргөж, илээр явуулах саналтай байна. Шалтгаан нь жишээлбэл Их Хурлын дарга гараад явчихсан. Тэгээд ирцдээ ингээд, үгүй ээ үгүй ирцээсээ ингээд гарах боломжгүй байгаад байгаа байхгүй юу. Одоо ингээд би өөрөө ингээд ирцээсээ гарахад л ирц хасагдахгүй байна. Тэгэхээр техникийн асуудал чинь болохгүй шүү дээ, энэ чинь хурлаа орхиод гараад явчхаж байгаа юм чинь. Ирцээс гарч болно шүү дээ хүн ч гэсэн, хэн ч гэсэн

гарч болно шүү дээ. Тийм. Тэгэхээр илээр санал хураах горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг гар өргөж, илээр явуулахыг дэмжье гэсэн гишүүд гараа өргөнө үү. Сайн тоолоорой. 20-оос 11. 20-оос 11. Сайн гараа өргөөрэй. 11 л байна даа Пүрэвдорж гишүүнээ, дахиад тоол. Учрал гишүүн мөн шүү дээ. 20-оос 11 гишүүн дэмжигдэж, санал хураалтыг гараар, илээр явуулахаар тохирлоо.

Сайнзориг гишүүний санал хураалт түрүүн зарчмын зөрүүтэй санал дээр 50, 50 хувь болсон учраас энэ санал хураалтыг хүчингүй болгохоор илээр санал хураая, гар өргөж. Санал хураалт. Сайнзориг гишүүний гаргасан саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор. Хэд вэ? 20-оос 11, сайн тоолоорой.

Горимын санал дэмжигдсэн учраас Сайнзориг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Санал хураалт. 20-оос, сайн тоолоорой, 11. Зөв үү? 11, дэмжигдлээ. Маш олон саналууд байна.

Ундрaм гишүүний гаргасан ЗГ-ын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний биеийн тамир спортыг хөгжүүлэх бодлого гэсний өмнөх нийтийн гэснийг хасах. Ундрaм гишүүний, Ундрaм гишүүн өөрөө байна уу? Зарчмын зөрүүтэй санал гаргаад. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний биеийн тамир спортыг хөгжүүлэх бодлого гэсний өмнөх нийтийн гэснийг хасах. Нийтийн биеийн тамир, спортын гэдгээс л нийтийг нь хасаж байгаа юм байна тийм үү? Хуульд нийцүүлж байгаа зарчмын зөрүүтэй санал юм байна. Санал хураалт. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Тоолоорой. Санал дэмжигдлээ. Өөр байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Доржханд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх ажлын хүрээний гадаадын хөрөнгө оруулалтын гэснийг гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын гэж өөрчлөх. Санал хураалт. Гайгүй юм биш үү? Санал хураалт. Ер нь дэмжчихэж байна олонхоороо. Тоолоорой хэдээс хэд вэ? 20-оос. Байна уу? Олонхоороо дэмжигдлээ. Санал дэмжигдлээ. Ахиад байна уу?

Сайнзориг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заалт. Монгол Улсын Шадар сайд, ЗГ-ын гишүүн энэ ерөөсөө. Сайнзориг гишүүн өөрөө зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо танилцуул даа. Сайнзориг гишүүний микрофон. Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Түрүүн зүгээр л байсан даа, яагаад бас гацчихав даа.

П.Сайнзориг: Ерөнхийдөө Монгол Улсын ЗГ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр Тэргүүн шадар сайд, Шадар сайд, Шадар сайд гээд бүгдэд, Тэргүүн шадар сайдаас бүх сайдуудын эрхлэх асуудлын хүрээнд төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал гэж оруулмаар байгаа юм. Яг агаарын бохирдол гэдэгтэй адил. Өөрөөр хэлэх юм бол иргэдийн мэдэх эрхийг хангая, авлигал, ашиг сонирхол бас ангид байя гэдэг энэ зориулалтаар энэ нийтийн мэдээллийн ил тод байдал нь бусад холбогдох хуулиудыг бүрэн хангаж ажиллая гэдэг чиг үүргийг оруулж өгөөч гэж хүсэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Шадар сайд, ЗГ-ын гишүүн бүрийн эрхлэх асуудлын хүрээнд төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах

асуудал гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Тоол, тоолоорой. Хэд вэ? Болсон уу? Хэд вэ? 20-оос 12 дэмжигдлээ. Өөр байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал гишүүнээс Монгол Улсын ЗГ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал гэснийг тохиолдол бүрд орчны бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал гэж өөрчлөх гэнэ үү? Саяын зарчмын зөрүүтэй санал дээр ажлын хэсгээс тайлбар байна уу? 3 номерын микрофоныг өгье. Ганбат дарга. 6 юм уу, 6 юм байна, 6.

Б.Ганбат: Энэ бүх ЗГ-ын гишүүдийн юун дээр энэ агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааны асуудал гээд бүгд дээр нь тавьсан байгаа. Энэ өмнөх одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр бас яг энэ заалтаараа байгаа. Тэгэхээр агуулгын хувьд бол агаарын бохирдол гэдгийг орчны бохирдол гэж өөрчлөхөд агуулгын зөрүү гарахгүй болбол энэ дээр бол бид нар зарчмын өөр санал бол алга байна. Тэгэхдээ агуулга нь, агуулга нь зөрүүтэй эсэх дээр нь нэлээн чеклэх тийм шаардлага болбол бас байна гэж байгаа. Ер нь бол засгийн, Ерөнхий сайдаас өргөн барьсан төсөл дээр болбол бид нар агаарын бохирдол гэдгээрээ оруулсан байгаа. Өргөн барьсан төсөл дээрээ.

Ц.Сандаг-Очир: Санал хураалт Баасанжаргал гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй.

Дараагийн Баасанжаргал гишүүний гаргасан төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар

зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлалын, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний залуучуудын хөгжлийг дэмжих бодлого гэснийг залуучуудын хөгжил оролцоог дэмжих бодлого гэж өөрчлөх. Тэгж байна, оролцоо гэдэг үг нэмж байна. Энэ дээр ажлын хэсгээс тайлбар байна уу? Залуучуудын хөгжлийг дэмжих бодлого гэснийг залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого л гэж байгаа юм байна. Энэ дээр. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Баасанжаргал гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал. Тоолоорой, хэд вэ? 10 гишүүн санал дэмжигдсэнгүй. Өөр байна уу? Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой санал хураалт дууслаа.

ЗГ-ын тухай хуульд, төслийн, ЗГ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Зарчмын зөрүүтэй санал байна уу? Байхгүй байхгүй байна.

3 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжинээс 3 дугаар зүйлтэй холбоотой, 3 дугаар зүйл, 3.20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайд гэсэн заалтын хэрэглэгчийн эрх ашигийг хамгаалах асуудал гэснийг хасаж, 3.20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 10 дугаар заалтад нэмэх. Тайлбарлах уу? Хаана байна вэ? Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Энэ хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой манайд бас нэлээн олон жил гажуудсан тогтолцоо явсан. Шударга бус өрсөлдөөн болон хэрэглэгчийн эрхийг нийлүүлээд нэг бүтэц болгоод, хоорондоо огт авцалдахгүй чиг үүргүүдийг ингээд нийлүүлж нэлээн их явсан юм. Тэгээд энэ удаа ЗГ бол энэ 2-ыг салгаж байна лээ. Нэг нь монополын эсрэг гээд, нөгөөдөх нь хэрэглэгчийн эрх ашиг гээд. Германы ЗГ-ын бүтэц зохион байгуулалт ингээд олон юмыг дуурайж байгаа бол Германы чинь

Хууль зүйн яамны үндсэн чиг үүргийнх нь нэг нь хэрэглэгчийн эрх ашиг байхгүй юу. Хүний эрхийн хамгийн анхдагч зөрчил дандаа түүн дээр илэрдэг гардаг. Тэрийг хангахын тулд систем бүхэлдээ ажилладаг. Тэгээд энэ чиг үүргийг нь Хууль зүйн яам руу шилжүүлчих юм бол илүү хариуцлага нэхэх боломж гарна.

2 дугаарт энэ яамны бүтцэд байвал Хууль зүйн байнгын хорооны хүрээнд энэ чиг үүргийн хэрэгжилтийг хянах боломж бас нэмэгдэнэ. Одоо бол Хууль зүйн байнгын хороо энэ чиг үүргийг хянахгүй байгаа. Өөрөөр хэлбэл парламентын хяналтаас гадуур явж байгаа гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүд гараа өргөж байгаа гишүүд өндөр өргөхгүй бол тоолж байгаа гишүүд харагдахгүй байна гэж байна. Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Тэмүүжин гишүүний гаргасан. Сайн тоолоорой. Хэд вэ? Санал дэмжигдсэнгүй, 20-оос 6.

Тэмүүжин гишүүний гаргасан 3.20.5-д Иргэний боловсролын албан болон албан бус хөтөлбөрийг хөтөлбөрийн дэмжих, дэмжин хэрэгжүүлэх гэж нэмэх. Тайлбар, саналаа тайлбарлах уу? Тэмүүжин гишүүний микрофон.

Х.Тэмүүжин: Мэдээж хэрэг боловсролын асуудлууд бол Боловсролын яаман дээр бүтнээрээ байгаа байх. Энэ ардчилал, хүний эрх, энэ Үндсэн хуулийн боловсрол буюу хуулийн системийн боловсролтой холбоотой асуудал дээр ер нь бол ардчилсан улс орнуудад Хууль зүйн яамны оролцоо заавал байж байгаа юм. Боловсролын яамтайгаа хамтарсан байдлаар эсвэл албан албан бус тогтолцоо дээр нь энэ иргэний боловсролыг дэмждэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр Монгол Улсад энэ боловсролын системийг хийж өгөхгүй бол үндсэндээ манайхан бол яаж байна вэ гэхээр Боловсролын яамны дотор иргэний боловсролын агуулга маш дутмаг, албан бус боловсрол нь бол бүүр огт байхгүй тэгж явж байгаа юм. Тэгээд энэ дээр зүгээр дэмжлэг үзүүлэх болон хэрэгжүүлэхтэй холбоотой нэг ийм зохицуулалт хийгээд өгчихвөл дараа нь Хууль зүйн яамнаас Улсын Их Хурал дээр хяналт тавиад шаардахад бас хэрэгтэй нэг сэжиг л байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Ойлголоо. Гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 8. Хэд вэ? 20-оос 8 санал дэмжигдсэнгүй.

3 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл, Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан нараас 3.20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1-д Тэргүүн шадар сайдын эрхлэх асуудлын шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого гэсний ард төлөвлөлт гэж нэмэх. Төлөвлөлт нь байхгүй болсон юм байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 20-оос 15 зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ. Өөр санал байна уу? ЗГ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын ЗГ-ын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Монгол Улсын ЗГ-ын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Монгол Улсын ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 2

дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Монгол Улсын ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу, байгаа юу? Зарчмын зөрүүтэй санал. Байхгүй байна. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. 4 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

8.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

9.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу, байна уу? Алга байна. 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

10.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Зөвшөөрлийн тухай хуулийг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

11.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй санал байна. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “бүсчилсэн хөгжлийн” гэж, мөн зүйлийн 7.6 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийн “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “Бүсчилсэн хөгжлийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.8 дахь заалтын “бүс нутгийн хөгжлийн” гэснийг “эдийн засаг, хөгжлийн” гэж тус тус өөрчилсүгэй. Зарчмын зөрүүтэй саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор. Гишүүд гараа өргөнө үү. 20-оос 11, санал дэмжигдлээ. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. 4 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

12.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Ариунзаяа гишүүн. Ариунзаяа гишүүний микрофон, Ариунзаяа гишүүний микрофон, наад юу чинь шууд товчоо дараад л орно доо. Тэр наад Сайнзориг гишүүн, Номинчимэг гишүүний микрофонууд асчхаад байх юм.

А.Ариунзаяа: Гишүүдээ яамны чиг үүрэг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэдгээрээ хэвээр үлдсэн учраас хуульд ч гэсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын гэдэг нь хэвээр нь үлдэх юм байна. Нийгмийн хамгааллын гэдэг нь. Тэгэхээр энийг хууль санаачлагчид буцаачихвал ямар ч өөрчлөлт орохгүй болох юм байна гэсэн ийм санал байна.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсэг юу гэж байна вэ, зөв үү? Ганбат 6 дугаар микрофон, 6 дээр зөв үү? 6.

Б.Ганбат: Тийм аль түрүүн ЗГ-ын бүтцийн тухай хууль дээр эрхлэх асуудлын хүрээ, дээр нь нөгөө яамны нэр дээр болохоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэдэг дэмжигдсэн учраас энэ саяын Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах юун дээр өөрчлөлт оруулаад байх шаардлага бол байхгүй болчхож байна. Тэгэхээр буцаах ийм боломж бол үүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор хууль санаачлагчид нь буцаах гэсэн зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Хэд вэ? 20-оос 11, зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Саяын санал дэмжигдсэнтэй холбогдуулаад 13.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт

орлуулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаалаа. Хураалгах юм байна тийм үү? Буцаах, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 20-оос 12 санал дэмжигдлээ.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн зарчмын зөрүүтэй саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 20-оос 12 дэмжигдлээ.

Дипломат яаж байна вэ? Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 үү? 20-оос 11 санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 20-оос 11 санал дэмжигдлээ.

17.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 20-оос 12 санал дэмжигдлээ.

18.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 дэмжигдлээ санал.

19.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

хууль санаачлагчид буцаая гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Учрал сайд санал хураалт. 20-оос 11 санал дэмжигдлээ.

20.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаая гэсэн томъёоллоор санал хураалт. Хэд вэ? Сайн, тодорхой өргөдөө гишүүдээ. 11, 20-оос 11.

21.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаая гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 үү? 20-оос 11 санал дэмжигдлээ.

22.Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр түрүүнд Сайнзориг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулаад Улсын бүртгэлийн ерөнхий газар гэснийг Монгол Улсын сайд, Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэж өөрчлөх. Санал хураалт. Түрүүний Сайнзориг гишүүний гаргасан санал дэмжигдсэн учраас. Учрал гишүүн санал хураалт. Тэгээд наадах чинь түрүүнд нөгөө Сайнзориг гишүүний санал дэмжигдчихээд, одоо дэмжигдэхгүй болохоор чинь тэгээд яана гэсэн үг юм бэ? 20-оос 9 үү? 20-оос 10. 20-оос 10 санал дэмжигдсэнгүй.

Тогтоол дээр Баасанжаргал гишүүнээс тогтоолын төслийн хавсралтын Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэсэн хэсэгт Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих газар гэж нэмэх. Энэ газар шинээр

байгуулах гэж байгаа юм уу? Та хасчихъя, саналаа татчихъя гэсэн үг үү? Баасанжаргал гишүүн өөрөө саналаа татаж байгаа учраас санал хураалгах шаардлагагүй. Болсон уу?

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Хаана тавив? Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Сая бас нэлээн олон саналууд унах шиг боллоо. Тэгэхээр санал унасан улсууд уг нь саналаа татчих юм болбол чуулганы хуралдаан дээр дахин, дахин санал хурааж цаг алдахгүй явчихна. Тийм болохоор нэгэнтээ дэмжигдэхгүй байгаа саналуудаа гаргасан улсууд нь татчихвал, дараа дараагийнхаа ажилд бас хэрэгтэй болов уу? Энийг бас гишүүд бас анхааралдаа авчхаач гэж хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Баасанжаргал гишүүн та гаргасан 2 саналаа дэмжигдээгүй учраас татчихъя гэдгээ саналаа хэлчих, микрофонд хэлчих, протоколд тэмдэглэе. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Энд асчихлаа. Зарчмын зөрүүтэй 3 санал гаргасан 3-ланг нь татчихъя гээд протоколд тэмдэглүүлчихье.

Ц.Сандаг-Очир: Баасанжаргал гишүүний гаргасан 3 саналыг өөрөө татаж байгаагаа мэдэгдэж байна. Тэмүүжин гишүүний 2 саналыг яах юм бэ, үгүй ээ татчихаж гэж болох юм уу? Болохгүй биз дээ дэг, өөрөө л байж яана. Одоо тэгээд. 1, 3 дугаар саналаа Баасанжаргал гишүүн татлаа. Оролцоо гэдэг нь дэмжигдсэн учраас ойлголоо, протокол сайн тэмдэглээрэй.

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийн

анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд, Номинчимэг гишүүнд юу байгаа юм бэ? Номинчимэг гишүүн микрофонд хэлчих.

О.Номинчимэг: Түрүүн гаргасан Болормаа гишүүн, Баярбаатар гишүүн бид гурвын гаргасан унасан саналыг бас татъя гэсэн саналтай байна.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн, Болормаа гишүүн, Номинчимэг гишүүн 3 гаргасан саналаа унасан саналаа татаж байгаагаа мэдэгдэж байна. Протоколд тэмдэглээрэй. Ингээд санал, дүгнэлтийг хэн танилцуулах юм бэ, хэн танилцуулах вэ нэгдсэн чуулганд? Амгаа гишүүн танилцуулах уу, хэн танилцуулах вэ? Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт гишүүн танилцуулна.

22.18 цаг

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан түр завсарлалаа.

Хуралдаан 2024.07.09-ний өдрийн 22 цаг 18 минутаас 2024.07.10-ны өдрийн 03 цаг 04 минут хүртэл завсарлав.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны гишүүддээ оройн мэнд хүргэе. Байнгын хорооны хуралдаанаар ирц Дэгийн тухай хуулийн шаардлага хангаж байгаа учраас хуралдааныг эхэлж байна. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн Засгийн газрын 2024 оны 7 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудал, хэлэлцэх асуудалдаа оръё.

Хоёр.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудлыг, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний талаар Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын Ерөнхий сайд 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ЗГ-ын бүтцийн тухай, ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан Их Хурал 2024 оны 7 сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн.

ТББХ 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10, 42 дугаар зүйлд заасан журмын дагуу ЗГ-ын бүтцийн тухай, ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 1 саналыг саналаар санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд, зарчмын зөрүүтэй санал болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэлээр өгсөн зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын заасны дагуу хураалгах санал. 1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний залуучуудын хөгжлийг дэмжих бодлого гэснийг залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого гэж өөрчлөх. Зарчмын

зөрүүтэй саналаас асуух асуулттай гишүүн байна уу?

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 20-оос 14, санал дэмжигдлээ. Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг танилцуулна.

03.07 цаг

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Бас завсарлаж байгаа юу? Түр завсарлаж байгаа юм байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

